



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/461

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.11, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 14 дүгээр тогтоол, Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт” 336 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан жагсаалтын 8.8, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 221 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалын 2.1.1, 2.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тариалсан ногоон тэжээлийг аймгийн өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд 10,000 боодлыг талбайгаас нь худалдан авахад 60,000,000 (жаран сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Шууд худалдан авах гэрээ байгуулж, ногоон тэжээлийн чанарт анхаарч аюулгүй нөөцөд авах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3.Дээрх 60,000,000 (жаран сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100979

D:My Doc. Zahiramj. Zasag darga